



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/136

Биндэр сум

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Намрын баяр-2026 үзэсгэлэн худалдааны зардалд 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөг, Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцад ханан пийшин хийлгэсэн ажлын зардалд 800,000 (найман зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 1,200,000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛСАЙХАН